



Баян-Өлгий аймгийн Ус цаг уур, орчны
шинжилгээний төв

Эрхэм хүндэт танаа

Тус хүрээлэн нь Монгол орны уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг байгаль, нийгэм, эдийн засгийн салбарын судлаачидтай хамтран хийдэг. Цаашид уг үнэлгээний орон зайн нарийвчлалыг ихэсгэж, бүс нутаг, голын сав газар гэх зэргээр улам сайжруулан хийхийг зорьж байна. Энэ зорилгоор аймгуудын УЦУОШТ, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран орон нутагт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулдаг.

Энэ жил Баян-Өлгий аймгийн УЦУОША байгуулагдсаны 60 жилийн ой тохиож байгаа тул тус аймагтай хамтран эрдэм шинжилгээний бага хурлыг “Уур амьсгалын өөрчлөлт: Мөстөл, мөсөн гол” гэсэн сэдвээр 2018 оны 7 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Өлгий хотод зохион байгуулахаар ажиллаж байна.

Иймд танай байгууллагаас тус хуралд илтгэл хэлэлцүүлж оролцохыг урьж байна. Илтгэгчийн нэр, тавих илтгэлийн нэрийг 6 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлэв. /..... хуудас/

Холбоо барих:

УЦУОСМХ-ийн Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн судалгааны хэлтсийн дарга,
доктор П.Гомболүүдэв,
Утас: 318751, 99256992
Электрон шуудан. p_gombo@hotmail.com

ЗАХИРАЛ



Г.САРАНТУЯА

“Уур амьсгалын өөрчлөлт: Мөстөл, мөсөн гол”

сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын өгүүлэл, илтгэлд тавигдах
шаардлага

Судлаачид та бүхнийг дээрх сэдэвтэй холбоотой судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг эмхэтгэсэн 3-4 А4 хуудас бүхий эрдэм шинжилгээний өгүүллийг доорх форматаар бэлтгэж 2018 оны 6 дугаар сарын 15-ны дотор дараахь электрон шуудангаар ирүүлнэ үү.

УЦУОСМХ-ийн УАӨНСХ-ийн дарга, доктор П.Гомболүүдэв,

Утас: 318751, 99256992

Электрон шуудан. p_gombo@hotmail.com

Эрдэм шинжилгээний өгүүлэл нь судалгааны ажлын товч тодорхой үр дүнг хураангуйлж шинжлэх ухааны үг хэллэгээр бичсэн байх, график, хүснэгт, диаграммын нэр, дугаарыг тавьсан байхын зэрэгцээ доорх бүтэц, форматтай байна. Үүнд: Microsoft Office Word ашиглах ба үсгийн хэмжээ 12 байх, стандарт Cyrillic Mongolian фонтоор бичнэ. Мөр хоорондын зай “single” байна.

Бүтэц:

Өгүүллийн нэр,

Зохиогчийн нэр, хаяг

Хураангуй (Англи)

Оршил

Арга зүй, ашигласан мэдээ

Үр дүн

Дүгнэлт

Ном зүй [Өгүүлбэрт иш татахдаа монгол бол (Д.Батбаяр, 2010) эсвэл англи бол (J.Beheng, 2002) гэж бичнэ. Ашигласан хэвлэлийг үсгийн дарааллаар жагсааж бичнэ.]

Жич: Ирүүлж буй өгүүлэл нь хэвлэлтэнд орох эцсийн хувилбар байхыг онцгой анхааруулж байна.